

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

Агуулга .....	2
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



МОН АТОМ ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Д.ДАЛАЙЖАРГАЛ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/849  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны Мон Атом ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Мон Атом ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мон Атом ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Мон Атом ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Мон Атом ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Далайжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон Атом ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мон Атом ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Мон Атом ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Мон Атом ХХК-нд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн анхан шатны чанарын хяналтыг захирал Ж.Цэцэгмаа, аудитыг аудитор Б.Мягмар, аудиторын туслахаар Э.Болд нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Мон Атом” ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/39 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мон Атом ХХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго “Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Монгол улсын нутаг дэвсгэрт уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, тандан судалгаа, хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийг тогтоох, тэдгээрийг олборлох, ашиглах, цөмийн түлш, эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх, тэдгээрт шаардлагатай материаллаг бааз болон үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, энэ салбар дахь гадны болон хувийн хөрөнгө оруулалттай төслүүдэд төрийн өмчийн оролцоог хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон.

Мон Атом ХХК-ийн 2019 оны бизнес төлөвлөгөө, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-өөс өгсөн үүргийн дагуу тус компани нь Цацраг идэвхт ашигт малтмалын өнөөгийн нөөцийг өсгөн нэмэгдүүлэх ажлын хүрээнд цацраг идэвхт ашигт малтмалын төрөлжсөн мэдээллийн сан бий болгох, уранжилтын хэтийн төлөв бүхий талбайг судалж урьдчилсан байдлаар ялгах, цаашид хайгуулын тусгай зөвшөөрөл авч хөрөнгө оруулагч татахаар ажиллаж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 382 тоот “Журам батлах тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот “Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Мон Атом ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамны хэмжээнд хийгдсэн “Байгууллага аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Тус баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт бүрэн нийцэхгүй байна.

Мон Атом ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Бааз” программ хангамж ашигладаг байна.

Мон Атом ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Мон Атом ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд тодорхойлж 7 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,475.7 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон 29.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 1,307.0 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон материаллаг байдлын түвшнийг 26.1 сая төгрөгөөр тогтоолоо.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мон Атом ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45.3 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7.3	34.4	27.1
Авлага	110.5	116.6	6.1
Бараа материал	1.7	8.8	7.1
Үндсэн хөрөнгө	40.1	45.0	4.1
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,575.2	1,575.2	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,927.2	1,927.2	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,661.9</b>	<b>3,707.2</b>	<b>45.3</b>
Дансны өглөг	3,974.8	5,349.9	1,375.1
Улсын төсөвт өгөх өр	218.0	0.4	(217.6)
Урт хугацаат өр төлбөр	5,682.3	5,877.1	194.8
Эздийн өмч /төрийн/	100.0	100.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	1,575.2	1,575.2	-
Хуримтлагдсан ашиг	(7,888.4)	(9,195.5)	(1,307.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,661.9</b>	<b>3,707.2</b>	<b>45.3</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 27.1 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн нь 2019 оны 12 дугаар сард Эрдэнэс Монгол ХХК-аас 2020 оны 1 дүгээр сарын санхүүжилтийг олгосонтой холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь нэмэгдсэн өртгийн албан татвартай бараа, ажил үйлчилгээ худалдан авснаас шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэл 116.6 сая төгрөгийг Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материалын худалдан авалтаас шалтгаалжээ. 2019 оны жилийн эцсээр 8.8 сая төгрөгийн хангамжийн материалын нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 9.6 сая төгрөгийн тавилга эд хогшил, компьютер худалдан авснаас шалтгаалжээ.

Дансны өглөг дансны үлдэгдэл өссөн нь “Эрдэнэс Монгол” ХХК-аас авсан санхүүжилт байна. Тайлант оны эцэст “Эрдэнэс Монгол” ХХК-нд өгөх өглөгийн 5,349.9 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 5,877.1 сая төгрөг байна.

Уг урт хугацаат өр төлбөрийг 2013 онд Увс, Ховд, Баян-Өлгий зэрэг баруун аймгуудын нутагт “уран”-ы нөөц илрүүлэх, тандалт судалгааны ажилд зориулан 2.15 сая долларыг Чех улсаас авсан.

## 2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн тодруулга

Засгийн газрын 2016 оны 28 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм”-ын 1.2-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар нь энэ тогтоолын 5 дугаар зүйлийн 5.1-д заасан чиглэлийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Орлогын үр дүнгийн тайлан

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Хүүгийн орлого		1.1	1.1	
Бусад орлого		0.05	0.05	
Ерөнхий ба удирдлагын зардал	804.9	681.2	(123.7)	84.6
Санхүүгийн зардал	384.7	384.7		100.0
Бусад зардал	53.6	47.5	(6.1)	88.7
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		194.8	194.8	
<b>Татвар төлөхийн өмнөх алдагдал</b>	<b>1,243.2</b>	<b>1,306.9</b>	<b>63.7</b>	<b>105.1</b>
Орлогын татварын зардал		0.1	0.1	
<b>Тайлант үеийн цэвэр алдагдал</b>	<b>1,243.2</b>	<b>1,307.1</b>	<b>63.9</b>	<b>105.1</b>
<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>1,243.2</b>	<b>1,307.1</b>	<b>63.9</b>	<b>105.1</b>

Тайлант онд Мон Атом ХХК-ийн хэрэгжүүлэх гадны хөрөнгө оруулалттай компани байгуулан цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан “Эрдэнэс Монгол” ХХК нь 1,306.9 сая төгрөгийн санхүүжилт батлан өгсөн байна.

Мон Атом ХХК нь ерөнхий ба удирдлагын зардалд 681.2 сая төгрөг зарцуулж зарим орон тоог хавсруулан ажилласнаар 123.7 сая төгрөгийг хэмнэжээ.

Зээлийн хүүгийн зардал төлөвлөсөн хэмжээнд байна. Харин бусад зардал 6.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь өөрсдийн хүчээр өр төлбөр барагдуулах ажлыг хийсэнтэй холбоотой байна.

Тайлант онд гадаад валютын ханш өссөнөөр гадаад төлбөрийн хүүгийн ханшийн гарз 194.8 сая төгрөг болсон.

Мон Атом ХХК нь тайлант онд 1,306.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг Эрдэнэс Монгол ХХК-аас 2019 оны бизнес төлөвлөгөөний дагуу авч цөмийн энергийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.0 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.



1. Түрээсийн төлбөр гэж хувь хүний дансанд шилжүүлсэн төлбөрөөс 0.2 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дүгээрт “албан татвар төлөгчийн орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг” албан татвар суутгагч гэж тодорхойлсны дагуу 10 хувиар албан татварыг суутган тооцоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Аудитаар илэрсэн 4.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Цаашид анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Мон Атом ХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 52 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15.6 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Мон Атом ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Мон Атом ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС -ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.1.1. Илрүүлэлт:

*Ажилчдын ажлын цагийн бүртгэл хөтлөөгүй, цалин бодож олгосон, албан томилолтын зарцуулалтын тайланг томилолтоор явсан ажилтнаас цаг хугацаанд нь гаргуулан авч тооцоо бодоогүй, 2.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна.*

##### 3.1.2. Эрсдэл:

*Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;*

##### 3.1.3. Өгсөн зөвлөмж:

*Албан томилолтоор ажиллагсдын гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гаргуулж, зохих хууль дүрэм журмын дагуу тооцоог бодох, ажлын цагийн бүртгэлийг хөтөлж хэвших.*

##### 3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

*Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

#### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

##### 3.2.1 Илрүүлэлт:

*Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчиж, 0.1 сая төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна. Энэ нь Монгол Улсын Засгийн 184 дүгээр тогтоолын 8. “Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, бүх*

шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай” –д нийцээгүй байна.

**3.2.2 Эрсдэл:**

Төсвийг үр ашиггүй, хяналтгүй зарцуулах,

**3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Монгол улсын засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 8 дугаар зүйлийг баримтлан ажиллах.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Цаашид анхааран ажиллана.

**3.3. Балансын данстай холбоотой асуудал**

**3.3.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн бүртгэлд 99 төрлийн 91.0 сая төгрөгийн хөрөнгийн элэгдлийн хугацаа дууссан боловч дахин үнэлээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны 271 дүгээр тогтоолын 7.1”Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлээгүй.

**3.3.2 Эрсдэл:**

Өмч хөрөнгөнд анхан шатны бүртгэлээр тавих хяналт суларна.

**3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны 271 дүгээр тогтоолын 7.1 зүйлийн дагуу үнийг шинэчлэн тогтоох.

**3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

**3.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал**

**3.4.1. Илрүүлэлт:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

**3.4.2. Эрсдэл:**

Бүртгэл тайлан алдаатай илэрхийлэгдэх.

**3.4.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн онцлогт тохируулан боловсруулж, мөрдөж ажиллах.

**3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

### **3.5. Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### **3.5.1 Илрүүлэлт:**

*Геологи хайгуулын инженерийн зөвлөх үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын гүйцэтгэлийн тайлан гаргуулж аваагүй 1.5 сая төгрөгийн ажлын хөлсийг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна.*

#### **3.5.2 Эрсдэл:**

*Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил, гүйлгээг данс бүртгэлд тусгасан.*

#### **3.5.3 Өгсөн зөвлөмж:**

*Гэрээгээр ажиллаж байгаа ажилчдын ажлын гүйцэтгэлийг гаргуулан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажлын хөлсийг тооцон олгож байх.*

#### **3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл /төгрөг/
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,301,696.55	34.398.469.82
1.1.2	Дансны авлага	1.200.000.00	
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	104.630.915.91	116.494.103.01
1.1.4	Бусад авлага	4.691.580.82	115.699.82
1.1.6	Бараа материал	1.659.801.58	8.785.487.32
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>119.483.994.86</b>	<b>159.793.759.97</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	40.069.269.50	45.001.282.83
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1.575.192.180.00	1.575.192.180.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1.927.177.212.00	1.927.177.212.00
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3.542.438.661.50</b>	<b>3.547.370.674.83</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3.661.922.656.37</b>	<b>3.707.164.434.81</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	3.008.345.393.08	4.121.918.075.66
2.1.1.2	Цалингийн өглөг	81.082.307.75	53.113.825.24
2.1.1.3	Татварын өр	47.648.508.40	420.008.25
2.1.1.4	НДШ–ийн өглөг	170.353.173.16	
2.1.1.5	Богино хугацаат зээл	94.980.935.00	
2.1.1.6	Хүүний өглөг	790.400.749.51	1.174.926.693.13
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4.192.811.066.90</b>	<b>5.350.378.602.29</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	5.682.278.000.00	5.877.068.000.00
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5.682.278.000.00</b>	<b>5.877.068.000.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	100.000.000.00	100.000.000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1.575.192.180.00	1.575.192.180.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(7.888.358.590.53)	(9.195.474.347.47)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(6.213.166.410.53)</b>	<b>(7.520.282.167.47)</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3.661.922.656.37</b>	<b>3.707.164.434.81</b>

## 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мерийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>29.508.600.00</b>	
2	Борлуулалтын өртөг	24.523.309.69	
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>4.985.290.31</b>	
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	927.502.22	1.144.121.89
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	49.500.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	20.000.00	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	515.593.863.15	681.180.638.40
11	Санхүүгийн зардал	334.171.979.46	384.664.788.18
12	Бусад зардал	88.066.438.90	47.502.249.49
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(463.933.500.44)	(194.785.334.55)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(1.395.843.489.42)</b>	<b>(1,306,939,388.73)</b>
19	Орлогын татварын зардал		176.368.21
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(1.395.843.489.42)</b>	<b>(1,307,115,756.94)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(1.395.843.489.42)</b>	<b>(1,307,115.756.94)</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(1.395.843.489.42)</b>	<b>(1,395,843,489.42)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>58.975.522.56</b>	<b>69.917.965.45</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	58.940.523.00	69.917.965.45
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	34.999.56	69.917.965.45
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>724.483.828.56</b>	<b>724,483,828.56</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	349.255.413.40	303.716.653.69
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	113.021.872.37	251.594.196.08
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	16.279.794.58	24.973.046.39
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4.788.119.73	11.075.636.08
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17.714.423.36	26.216.041.84
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	55.870.317.50	79.1958.823.36
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	167.553.887.62	219.572.503.25
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(665.508.306.00)</b>	<b>(846.425.935.24)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1.927.502.22</b>	<b>11.950.078.89</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1.000.000.00	10.805.957.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	927.502.22	1.144.121.89
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>100.621.532.69</b>	<b>197.070.052.82</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		9.618.181.82
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	100.621.532.69	187.451.871.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(98.694.030.47)</b>	<b>(98,694,030.47)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1.065.745.956.22</b>	<b>1.153.762.462.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн	1.065.745.956.22	1.153.762.462.00

	авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>305.146.113.56</b>	<b>305,146,113.56</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	305.146.113.56	95.119.779.56
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>760.599.842.66</b>	<b>1.058.642.682.44</b>
<b>4</b>	Валютын ханшийн зөрүү		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3.602.493.81)</b>	<b>27.096.773.27</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>10.904.190.36</b>	<b>7.301.696.55</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7.301.696.55</b>	<b>34.398.469.82</b>



## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000.0</b>	<b>1,575,192,180.0</b>	<b>(6,492,515,101.1)</b>	<b>(4,817,322,921.1)</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл	<b>100,000,000.0</b>	1,575,192,180.0	<b>(6,492,515,101.1)</b>	<b>(4,817,322,921.1)</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			<b>(1,395,843,489.42)</b>	<b>(1,395,843,489.42)</b>
5	Өмчид гарсан өөрчлөлт				
6	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000.0</b>	<b>1,575,192,180.0</b>	<b>(7,888.358.590.53)</b>	<b>(6,213.166.410.53)</b>
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
8	Залруулсан үлдэгдэл	100,000,000.0	1,575,192,180.0	(7,888.358.590.53)	(6,213.166.410.53)
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,307.115.756.94)	(1,307.115.756.94)
10	Өмчид гарсан өөрчлөлт				
11	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000.0</b>	<b>1,575,192,180.0</b>	<b>(9,195.474.347.47)</b>	<b>(7,520.282.167.47)</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Шалгагдсан байгууллагын нэр:	Мон Атом ХХК	Аудитын код:	САГ-2019/14/СТА-ТӨҮГ
Аудитын нэр:	Мон Атом ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	9	10
1	Түрээсийн төлбөр гэж хувь хүний дансанд шилжүүлсэн 2,2 сая төгрөгнөөс хувь хүний орлогын албан татварын суутган тооцоогүй.	0.2	Төлбөрийн акт тогтоох	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Батзаяа
2	Албан томилолтын тайланг цаг хугацаанд нь гаргаж ,тооцоо бодоогүй.	2.5	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Батзаяа
3	Үндсэн хөрөнгийн бүртгэлд нийт 196 бүртгэлтэй байснаас 99 төрлийн хөрөнгийн элэгдлийн хугацаа дууссан байна.		Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Батзаяа
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Батзаяа
5	Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчсөн.		Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Батзаяа
6	Геологи хайгуулын инженерийн зөвлөх үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлдэг боловч ажлын гүйцэтгэлийн тайлан гаргуулж аваагүй ажлын хөлсийг олгосон..	1.5	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Д.Далайжаргал, Батзаяа
<b>Нийт дүн</b>		<b>4.2</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/67

Улаанбаатар хот

СРГ- 0020/14/СТА - ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мон Атом ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түрээсийн төлбөр гэж хувь хүний дансанд шилжүүлсэн 2,200.0 мянган төгрөгнөөс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй олгосон.

Энэ нь тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 “албан татвар төлөгчийн орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг” албан татвар суутгагч гэж тодорхойлсны дагуу хувь хүнд шилжүүлсэн 2,200.0 мянган төгрөгнөөс “энэ хуулийн 23-р зүйлийн 1-д заасны дагуу “10 хувиар албан татвар ногдуулна”, 2019 онд батлагдсан ХХОАТ тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1 –ийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 220.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, төсвийн орлого болгож, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Төлбөрийн актын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Санхүүгийн аудитын газарт ирүүлэхийг Мон Атом ХХК-ийн захирал Д.Далайжаргал, ерөнхий нягтлан бодогч Д.Батзаяа нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР *И.Эрдэнэцэцэг* И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
РЕЛАЗНС СЕКЮРИТИЗ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*Ж.Цэцэгмаа* Ж.ЦЭЦЭГМАА

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

Д.ДАЛАЙЖАРГАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Д.БАТЗАЯА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

